



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/113

Ховд

Г Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай Г


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Тахилт багийн нутаг дэвсгэр Шинэ хорооллын бүсэд шүүхийн цогцолборын дэргэд 7000 метр квадрат газрыг Ховд аймгийн Цагдаагийн газар /9066381/-д албан конторын зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/647 дугаар захирамжийн 1.6 дахь заалтыг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/113 Ch  
02 00498